


Цамбын ЖАРГАЛСАЙХАН



СОЁЛЫН ЛАВЛАХ ТОВЧООН

- СОЁЛ СУДЛАЛ
- СОЁЛЫН ӨВ
- СОЁЛЫН ЭРХ ЗҮЙ
- СОЁЛЫН БАЙГУУЛЛАГА
- СОЁЛД ХОЛБОГДОЛТОЙ ҮЙЛ ЯВДАЛ

Улаанбаатар 2015

юм. Насны ойг хүүхдийн, өндөр насны гэж ангилж болно. Монгол заншлаар хүний насыг тоолохдоо хаврын эхэн сарын шинийн нэгэн жилийн хэмжээс болгон цагаан сараар нас нэмдэг гэж үздэг. Шинэ оныг төрсөн өдрийн баяртай хамтатган тэмдэглэж иржээ. Хүмүүн төрснөөс хойш нэг жилийн дараа хамаатан садан, найз дотно хүмүүс хүрээнд хүүхдийн насны ойн найрыг хийдэг. Энэ ёслолын үед хамгийн хоймор цагаан эсгий дэвсэн ойг нь тэмдэглэж буй хүүхдийг сүмд найрладаг ба түүнд хандан ерөөл хэлдэг заншилтай. Мөн хөгжсөн 5 нас хүрмэгц түүнд тусгай эмээл төхөөрөн дуртай сайн моринд зүслэн зааж өгч, төрсөн өдрийнх нь ойг тэмдэглэхдээ эмээлийн тохон моринд мордуулж, хултай айргаар морины толгой, дэл, хамрын мялаан үлдсэнийг тэр хүүд уулгадаг нэгэн сонин сайхан заншилтай. Ингэхдээ шинэ эмээлийг моринд тохоод эцэг нь эхэлж моринд дараа хүүгээ унуулан морины цулбуураас хөтлөн хотоо нар зурхай тойрч “Хонхор дүүрэн морьтой, Хот дүүрэн малтай, Үрээн дүүрэн Үрээгээ хөтлөөд яваарай” хэмээн ерөөл бэлгийн үг хэлдэг байна.

Монголын уламжлалт заншил ёсоор бол 70, 85, 90 насанд өндөр насны ойг тэмдэглэдэг бөгөөд найрыг үр хүүхэд, садан төрөл нь нутгийн ард олныг урин залж өргөн дэлгэр хийдэг. Тэгэхдээ зуны дунд айраг цагаа бэлтгэн найрлаж, бөх барилдуулж, морь уралдуулж, ёсны багахан наадам хийдэг заншил бий. 85, 90 насны ойг үр хүндэтгэлтэй тэмдэглэдэг бөгөөд буянтай бууралд хандан сүмд Найрыг дэгийн дагуу хийнэ.

НАУРЫЗЫН БАЯР Исламын шашинтай улс үндэстнүүд жамуа гуравдугаар сарын 22-ы өдөр, шөнө тэнцсэн өдөр тэмдэглэдэг. Хүйтэн өвлийг өнтэй давж, урин хаврыг угтан авч буйн бэлтгэлтэй баяр- хаврын баяр. Наурызын баярыг 3000 жилийн тэртээгээс үргэлжлэлтэй гэдэг. Өдгөө дэлхий даяар тархан суурьшсан казах үндэстнүүд Казахстан, гэр бүлийн, танил дотно хүмүүсийн хүрээнд, Азербайжан, Афганистан, Гүрж, Ирак, Иран, Казахстан, Косово, Кыргызстан, Монгол, Узбекистан, Тажикстан улсад өргөн тэмдэглэдэг. Баяраар аарцаар амталсан хөц будаатай шөл (наурыз-какс) төрлийн амттай хоол хүнс ихээр бэлтгэж, гэр бүл, найз дотно баярлан цэнгэж, ахмадууддаа золгож хүндэтгэл үзүүлж, хөгжсөн огт хэрэглэдэггүй. Ширээн дээр хэр амттай, олон төрлийн хоол бэлтгэсэн байхаас ирэх жилийн өнгө тодорхойлогдоно гэж үздэг. МУЗГ-ын 2010.7.7-ы өдрийн 172-р тогтоолоор Наурызын баярыг тэмдэглэлт өдрийн жагсаалтад оруулжээ.